



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.08 № ХЭГ/1543  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн биелэлтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуултын хүрээнд дараах хариуг хүргүүлж байна.

**Асуулт 1:**

Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны мэдээ нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас ([www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn))-д нээлттэй байршсан байдаг.

Тус зөвлөлөөс эмхэтгэн гаргадаг Монгол Улсын шүүхийн тухайн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээнд дурдсанаар Захиргааны хэргийн анхан шатны шүүх Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой 108 хэргийг 2020 онд, 75 хэргийг 2021 онд, 67 хэргийг 2022 онд, 72 хэргийг 2023 онд, 126 хэргийг 2024 онд, 132 хэргийг 2025 онд тус тус шийдвэрлэсэн байна.

**Асуулт 2:**

“Шивээ-Овоо” ХК-аас ирүүлсэн тайлбарт дурдсанаар тус компанийн 2021 оны зуны дизель түлш худалдан авах ажиллагаа нь коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын сөрөг нөлөө, дизель түлшний үнийн өсөлт зэрэг нөхцөл байдлын улмаас хоёр удаа амжилтгүй болсон бөгөөд 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /хүчингүй болсонд тооцсон/-ийн 30 дугаар зүйлийн 30.4.3-т заасныг үндэслэн 9 компанитай шууд гэрээ байгуулж, олон удаагийн худалдан авалтаар нийт 7.9 тэрбум төгрөгийн дизель түлш худалдан авсан байна.

Харин асуултад дурдсан ШО/202107367 тендерийн код бүхий өвлийн дизель түлш худалдан авах тендерийн урилгыг 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдөр зарлаж, 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдөр тендерийн баримт бичигт тодруулга оруулсан талаар тус компаниас тайлбар ирүүлсэн болно.

Захиалагчид болон захиалагчийн шийдвэрт гомдол гаргахтай холбоотой хуульд заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд ч хууль тогтоомж зөрчсөн эсэх асуудлаар хууль, хяналтын байгууллагад хандаж, шалгуулах боломжтой бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан

авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 55 дугаар зүйлийн 55.1.12-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр энэ хуулийн хэрэгжилттэй холбогдуулж тодорхой асуудалд зөвлөмж өгөх” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг Танд уламжилж байна.

### **Асуулт 3:**

2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /хүчингүй болсонд тооцсон/-ийн 15, 16 дугаар зүйлд зааснаар захиалагч нь шаардлагатай ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан тендерийн баримт бичигт тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, ирүүлэх баримт бичгийг заахаар, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 15, 16, 17 дугаар зүйлд зааснаар мөн захиалагч нь гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтээс аль шаардлагатайг тендер шалгаруулалтын баримт бичигт заахаар тус тус хуульчилсан бөгөөд эдгээр зохицуулалтуудын хүрээнд тухайн тендер шалгаруулалтын баримт бичигт зохих шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулах нь захиалагчид хуулиар олгосон эрх хэмжээний асуудал болно.

### **Асуулт 4:**

Худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээс үзэхэд “Шивээ-Овоо” ХК-аас 2020-2025 онд зарласан ШО/202107367/01/01, ШО/202209154/01/01, ШО/202201050/01/01, ШО/202201049/01/01, ШО/202301049/02/01, ШО/20240102391/04/01, ШО/20240102031/02/01, ШО/20250102029/01/01 дугаартай тендер шалгаруулалтуудыг хуульд заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргын дагуу зохион байгуулсан байна.

Түүнчлэн, тухайн тендер шалгаруулалтын шаардлага, техникийн тодорхойлолт бүхий тендерийн баримт бичгийг цахим системд ил тод, нээлттэй байршуулсан байх тул 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /хүчингүй болсонд тооцсон/-ийн 6 дугаар зүйлд заасан ил тод, өрсөлдөх тэгш боломжтой байх зарчимд нийцсэн гэж үзэх үндэслэлтэй.

2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /хүчингүй болсонд тооцсон/-ийн дагуу худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр нээлттэй тендер шалгаруулалтын аргын дагуу зохион байгуулсан тендер шалгаруулалтад нэг оролцогч тендер ирүүлсэн бол захиалагч тухайн тендерийг хянан үзэж, үнэлсний үндсэн дээр шаардлага хангасан тохиолдолд тус хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох, хэрэв тендер шаардлагад нийцээгүй тохиолдолд мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр түүний тендерээс татгалзах зохицуулалттай. Харин тендер шалгаруулалтад нэг оролцогч тендер ирүүлсэн гэж татгалзах боломжгүй юм.

### **Асуулт 5:**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Захиалагч тендер тус бүрд дараах шийдвэрээс аль тохирохыг гаргана: ... 28.1.3.шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах” гэж, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиалагчийн энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдлыг уг шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор ... хүлээн авна.” гэж тус тус заасан.

Тухайн тендер шалгаруулалтад оролцогч “НИК” ХХК өөрийн тендерийг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангаагүй гэсэн захиалагч “Шивээ-Овоо” ХК-ийн шийдвэрийг эс зөвшөөрч дээр дурдсан зохицуулалтын дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргаагүй байна.

### **Асуулт 6:**

“Өү Жи энержи ойл” ХХК нь “Шивээ-Овоо” ХК-ийн зарласан ШО/202107367/01/01, ШО/202209154/01/01, ШО/202201050/01/01, ШО/202201049/01/01, ШО/202301049/02/01, ШО/20240102031/02/01, ШО/20240102391/04/01 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтуудад ганцаараа оролцож, шалгарсан байгаа бөгөөд эдгээр шалгаруулалттай холбоотой 2021-2023 оны баримт бичгийг Авлигатай тэмцэх газарт 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдөр эх хувиар нь хүргүүлсэн тул тус компанид байхгүй талаар тайлбарыг “Шивээ-Овоо” ХК-аас ирүүлсэн болно.

Захиалагчид болон захиалагчийн шийдвэрт гомдол гаргахтай холбоотой хуульд заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд ч хууль тогтоомж зөрчсөн эсэх асуудлаар хууль, хяналтын байгууллагад хандаж, шалгуулах боломжтой бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 55 дугаар зүйлийн 55.1.12-т санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр энэ хуулийн хэрэгжилттэй холбогдуулж тодорхой асуудалд зөвлөмж өгөх” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасныг Танд уламжилж байна.

Асуулттай холбогдуулан “Шивээ-Овоо” ХК-аас ирүүлсэн тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 16 хуудастай.




Монгол улсын засгийн газар

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга

Б.Энхбаяр

2026.05.08 18:01



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

### ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК

Эрдэнэс Монгол ХХК-ийн байр, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 7555 3399,

Цахим шуудан: info@erdenesmongol.mn,  
Цахим хуудас: www.erdenesmongol.mn

2026.05.04 № 01/644  
танай 2026.04.28-ны № 237/1401 -т

### Хариу хүргүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан “Шивээ Овоо” ХК-ийн худалдан авах ажиллагаатай холбоотой ирүүлсэн асуулгын талаар тус компаниас ирүүлсэн тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ДАВААДАЛАЙ

1526061596



ШИВЭЭ ОВОО  
ХУВЬЦААТ КОМПАНИ

42020 Сэвхүүл, Шивээговь сум, Говьсүмбэр аймаг,  
Утас/Факс: (976) 7054-6464

2026.05.01 № ДБ/393

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ДАВААДАЛАЙ ТАНАА

Танай 2026 оны 01/620 дугаартай албан бичгийн дагуу хариу тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: хуудастай

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БАТСУУРЬ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн  
26/393 дугаартай албан бичгийн хавсралт

**Асуулт 1:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн талаарх шүүхээр шийдвэрлэгдсэн маргаан, түүний шийдвэрлэлтийн талаарх 2020-2025 оны байдлаарх ерөнхий статистик мэдээлэл;

**Тайлбар 1:** Тус компанид 2020-2025 онуудад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн талаар шүүхээр шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргааны гомдол маргаан байхгүй болно.

Хүснэгт: №01

№	Хэрэгний дугаар	Хэрэгний төрөл	ТЭ-ийн нэвд	ТЭ-ийн нэр	Засаг захиргаа/Орон нутаг	ТЭ-ийн төлөө	ТЭ-ийн төлөө	ТЭ-ийн төлөө, арга	Цэвэр хэргийн төлөө	Хэргийн төлөө	Хэрэгний төлөө, арга	ТЭ-ийн төлөө
1	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
2	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
3	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
4	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
5	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
6	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
7	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
8	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
9	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...
10	...	...	...	...	...	...	...	...	...	...	...	...

/Тайлбар: 2020 онд зарлан амжилтгүй болсон сонгон шалгаруулалтын мэдээлэл/

2020 онд Covid-19 цар тахлын үед дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтуудыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар төрийн худалдан авах ажиллагаа/tender.gov.mn/-ны цахим сайтад 10 удаа зарласан боловч оролцогчгүйн улмаас амжилтгүй болсон байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.3 дахь заалтыг үндэслэл болгон шууд гэрээ байгуулах аргаар 16 компаниас олон удаагийн худалдан авалтаар 8.3 тэрбум төгрөгийн дизель түлш худалдан авах ажиллагааг зохион байгуулж үйлдвэрлэлийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажилласны үр дүнд Монгол Улсын эрчим хүчний салбарын цахилгаан, дулааны станцуудыг нүүрсээр тасралтгүй ханган нийлүүлэх үүргээ гүйцэтгэж ажилласан байна. Тухайн үед түлш шатахуун хомсдолтой, импортлогч компаниуд бэлэн төлөлттэй нөхцөлөөр дизель түлшийг нийлүүлж байсан нь санхүү, мөнгөн урсгалын хувьд ихээхэн хүндрэлтэй цаг хугацаа байсан билээ.

**Асуулт 2:** Тус хуулийн хэрэгжилттэй холбогдуулан иргэдийн өргөдөл, гомдолд дурдсан “Шивээ Овоо” ХК-ийн 2021-2025 онд зарласан тендерүүдэд хууль хэрэгжихгүй байгаа талаар баримтыг хүргэж байна. “Шивээ Овоо” ХК-аас ШО/202107367/01/01 дугаартай 9,461,522,058 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг 2021 оны 07 сарын 28-ны өдөр tender.gov.mn цахим хуудсанд Тендерийн баримт бичиг буюу Тендер

шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт (ТШӨХ)-н 18 дугаар зүйлд заасан дараах шаардлагыг хангасан баримт бичиг хүлээн авахаар байршуулсан.

- ТШӨХ "18.1 (б)-д Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: [2020 он], [Аудитын дүгнэлтийн хамт];

- ТООЗ 18.1 (г) Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: [2020-2021 он], [маягтын хамт гэрээний хуулбар],

- Одоо хэрэгжиж буй гэрээний талаарх мэдээлэл;

- ТООЗ 18.2 (б) Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: [2020-2021 он];

- ТООЗ 18.2 (д) Ашигтай ажилласан байх жилийн тоо: [2020 он];

- ТООЗ 17.1 (в) Тусгай зөвшөөрөл: [Шаардлагатай] гэж тус тус заасан.


Гэтэл 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр үүсгэн байгуулсан ажлын болон санхүүгийн туршлагагүй "Өү Жи Энержи Ойл" ХХК-ийг өрсөлдөгчгүйгээр шалгаруулж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон ТШӨХ-д заасан шаардлага шалгуурыг зөрчин 9,461,522,058.00 төгрөгийн төсөвт өртөг бүхий тус тендерийг өгсөн нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн эсэх;

**Тайлбар 2:** "Шивээ Овоо" ХК нь ТУЗ-ийн 2020.12.31-ны өдрийн №17 тоот тогтоолоор батлагдсан 2021 оны бизнес төлөвлөгөөнд 7.2 сая.литр дизель түлшийг 12.8 тэрбум төгрөгөөр буюу нэг литр дизель түлшийг 1760 төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн. Үүнээс:

- ШО/202101219 дугаартай 5.263.947.150 төгрөгийн төсөвт өртөг бүхий зуны дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг 2021.01.29-ны өдөр зарлан 2021.03.01-ны өдөр нээсэн боловч оролцогчгүйн улмаас амжилтгүй болсон байна.

- ШО/202101219 дугаартай 5.263.947.150 төгрөгийн төсөвт өртөг бүхий зуны дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг 2 дахь удаагаа 2021.03.15-ны өдөр дахин зарлан 2021.04.16-ны өдөр нээсэн боловч оролцогчгүйн улмаас мөн амжилтгүй болсон байна. Уг сонгон шалгаруулалтын баримт бичигт 3.190.271 литр дизель түлшийг нэгж үнийг 1650 төгрөгөөр тооцон нийт 5.263.947.150 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр тооцон зарласан. Гэвч Covid-19 цар тахлын улмаас үүссэн нийгэм эдийн засгийн хүндрэлийн нөлөө, хямралын улмаас хил гаалийн нөхцөл хүндэрсэн, тээвэр ложистик доголдсон, импортоор орж ирэх дизель түлш тасалдсан, хомсдол үүссэн, түлш импортлогч аж ахуйн нэгж компаниудын үйл ажиллагаа доголдсон, зарим нь зогссонтой холбоотой 2020 оны жилийн эцсээс дизель түлшний литр тутмын үнэ өдөр бүр өссөөр 2021 оны 04 дүгээр сарын байдлаар 2250 төгрөгийн үнэтэй болж 37.8 хувиар өссөн байсан. Энэ нь уг сонгон шалгаруулалт амжилтгүй болох үндсэн шалтгаан болсон.

ГОЛ НЭРИЙН ЗАРИМ БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, бараа, үйлчилгээний төрөл, аймаг, нийслэл, сараар - 1212 ттгг




/Тайлбар: Үндэсний Статистикийн Хорооны тоон мэдээлэл/

Иймд дээр дурдсан тендерүүдийг зарлах хугацаанд уурхайн олборлолтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах үүднээс тухайн үед мөрдөгдөж байсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30.4.3 дахь заалтыг үндэслэл болгон 9 компаниас олон удаагийн худалдан авалтаар 7.9 тэрбум төгрөгийн дизель түлш шууд гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2021 оны бизнес төлөвлөгөөнд 4.050.775 литр өвлийн дизель түлшний нэгж үнийг 1870 төгрөгөөр тооцон нийт 7.574.949.250 төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн байсан хэдий ч дизель түлшний үнийн өсөлтөөс шалтгаалан 2021 оны бизнес төлөвлөгөөнд тодотгол оруулах зайлшгүй нөхцөл байдал үүссэн.

График: №02



/Тайлбар: Үндэсний Статистикийн Хорооны тоон мэдээлэл/

2021.06.24-ны өдөр ТУЗ-ийн хурлаар тодотголын саналыг хэлэлцүүлэн батлуулж дизель түлшний нэгж үнийг 2200 төгрөг болгон нэмэгдүүлэн ШО/202107367 дугаартай 9,461,522,058.00 төгрөгийн төсөвт өртөг бүхий өвлийн дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг 2021.07.28-ны өдөр зарлан 2021.08.23-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /tender.gov.mn/-д тодруулга тайлбар оруулсан. Уг сонгон шалгаруулалтад тодруулга оруулсан шалтгаан нь дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд хил гааль хаагдсан, дотоодод хөл хорио тогтоосонтой холбоотойгоор зарим аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон, борлуулалт хийгдээгүй улмаас 2020 оны санхүүгийн болон аудитын тайлан гаргаж амжаагүй нь нөлөөлж 12 удаагийн сонгон шалгаруулалтад нэг ч оролцогчгүй, амжилтгүй болсон байх магадлалтай гэж үзсэн.

Холбогдох бичиг баримтууд

Бичиг баримт /баримт/ Огноо

Тодруулга	Огноо
Тендерний баримт	2021-08-23 16:12
Баримт	
Санхүүжилт	
Мөн ШО/202107367	
2021 оны	
Санхүүжилт	
Төсөв	
Аудитын	
Дүнгийн тайлан	
Ажлын үндэслэл	
Тухайн үйл ажиллагааны	
<b>[Шалгардаггүй]</b>	
Бичиг	
Мөрдөлийн	
Сандруулга	
Оруулж байна	

/2021.08.23-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулсан өөрчлөлт/

Иймд шатахуун импортлох тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч 100 гаруй аж ахуй нэгжийг компанийг тендерт нээлттэй өрсөлдөх боломжийг олгох, нээлттэй тендер шалгаруулалтыг үр дүнтэй зохион байгуулах, мөн компанийн борлуулалт буурсан, мөнгөн урсгал багассаны улмаас цаашид бэлэн төлөлтөөр дизель түлш худалдан авалт хийн үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах маш

хүндрэлтэй байсан тул аль болох хурдан хугацаанд нийлүүлэлтийг хийх нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулахаас өөр аргагүй нөхцөл байдал үүссэн.

2021.08.30-ны өдөр нээсэн өвлийн дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтад ганц компани оролцсон бөгөөд үүсээд байсан нөхцөл байдлыг харгалзан үнэлгээний хорооны гишүүдийн шийдвэрээр “Өү Жи Энержи Ойл” ХХК-ийг сонгон шалгаруулсан. Уг сонгон шалгаруулалтад энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгч бусад компаниуд оролцсон тохиолдолд өрсөлдөөний зарчмыг баримтлан тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлт шаардлагыг хангасан компанийг сонгон шалгаруулж ажиллах байсан. Мөн сонгон шалгаруулалтад оролцогч “Өү Жи Энержи Ойл” ХХК нь тендерийн баримт бичигт нэг литр дизель түлшийг 2200 төгрөгөөр нийлүүлэх санал ирүүлсэн нь тухайн үеийн зах зээлийн түлшний үнээс 13%-аар хямд байсан тул сонгон шалгаруулах шалтгаан болсон юм.

Хүснэгт: №02.

Нэр төрөл	2021											
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Бензин, А-80, 1 литр	1 383	1 383	1 383	1 383	1 395	1 395	1 990	1 990	1 990	1 990	2 117	2 135
Бензин, А-92, 1 литр	1 432	1 445	1 445	1 444	1 450	1 450	2 044	2 047	2 047	2 048	2 151	2 196
Дизелийн түлш, 1 литр	2 075	2 161	2 168	2 171	2 267	2 277	2 486	2 486	2 486	2 520	2 785	2 858

*/Тайлбар: Үндэсний Статистикийн Хорооны тоон мэдээлэл/*

Хэрэв ШО/202107367 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг амжилтгүй болгон дахин зарласан ч эцсийн үр дүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа дизель түлшгүйн улмаас зогсох, улмаар өвөлжилтийн бэлэн байдлыг хангаж ажиллаж чадахгүй цахилгаан станцуудын нүүрсний нийлүүлэлтийг тасалдуулж Монгол Улсын эрчим хүчний салбарт доголдол үүсэж болзошгүй байсан.

Дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахлын улмаас үүссэн нийгэм эдийн засгийн хүндрэлийн нөлөө, хямрал бүрэн арилаагүй үед Монгол Улсын дотоодын цахилгаан дулаан эрчим хүч үйлдвэрлэгч станцуудыг эрчим хүчний нүүрсээр тасралтгүй хангаж ажиллах нийгмийн хариуцлагын хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг доголдолгүй, тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай дизель түлшний нөөцийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага үүссэн. Харин тендерт шалгарсан “Өү Жи Энержи Ойл” ХХК нь тухайн хүндрэлтэй цаг үед дизель түлшний нийлүүлэлтийг тасалдалгүй ханган гэрээний үүргээ биелүүлж ажилласнаар үүсээд байсан нөхцөл байдлыг хүндрэлгүй даван туулсан билээ.

**Асуулт 3:** “Шивээ Овоо” ХК-аас ШО/202201049/01/01 дугаартай 8,410,317,080 төгрөгийн төсөвт өртөг бүхий нээлттэй тендер шалгаруулалтын зарлалыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр tender.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Тендерийн баримт бичигтэй танилцахад Тендерийн өгөгдлийн хүснэгт (ТӨХ)-ийн ТШ318.2.4-т Борлуулалтын хэмжээ: [Шаардлагагүй] гэж заасан нь хуульд нийцсэн эсэх;

**Тайлбар 3:** “Шивээ Овоо” ХК-аас 2022.01.31-ны өдөр зарлагдсан ШО/202201049 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын

баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-18.2.4-т борлуулалтын хэмжээ шаардлагагүй гэж заасан нь

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах үйл ажиллагааг цаг хугацаа алдалгүй амжилттай зохион байгуулж 2020, 2021 онд үүссэн эрсдэлийг дахин давтагдахгүй байх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх

- Дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахлын нийгэм эдийн засгийн хүндрэлийн нөлөө хямрал бүрэн арилаагүй үед Монгол улсын дотоодын цахилгаан дулаан эрчим хүч үйлдвэрлэгч станцуудыг эрчим хүчний нүүрсээр тасралтгүй хангаж ажиллах үүргийн хүрээнд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад шаардлагатай дизель түлшний нөөцийг бүрдүүлэн өвлийн ид ачааллын хүндрэлийг даван туулах зорилгоор тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүдийг тооцон тусгасан болно.

- ТШЗ-18.2.4-т борлуулалтын хэмжээ шаардаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчөөгүй, ямар нэгэн компанийг тусгайлан дэмжих зорилго агуулаагүй бөгөөд Монгол Улсад шатахуун импортлох тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдийг нээлттэй өрсөлдөх боломжийг дэмжсэн гэж үзэж байна.

**Асуулт 4:** *“Шивээ Овоо” ХК-аас ШО/202201050/01/01 дугаартай 9,880,247,520 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/202209154/01/01 дугаартай 9,797,894,150 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/202301049/02/01 дугаартай 33,953,742,537 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/2024010231/02/01 дугаартай 26,752,393,773 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер, ШО/20240102391/04/01 дугаартай 4,080,474,090 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендерүүдэд “Өү Жи Энержи Ойл” ХХК өрсөлдөгчгүй оролцож, ялалт байгуулсан үйлдэл хуульд нийцсэн эсэх;*

*Мөн дээрх тендерүүдийн эхний хоёр тендер болох 9,880,247,520 болон 9,797,894,150 төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт оролцох хуулийн этгээдийн борлуулалтын хэмжээ шаардлагагүй, ижил төстэй ажлын өртөг шаардахгүй, түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ тус тус шаардлагагүй гэж ТШӨХ-д бичсэн нь “Өү Жи Энержи Ойл” ХХК-ийн тухайд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 2005 оны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж заасан өрсөлдөх тэгш боломж, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчим зөрчигдсэн эсэх;*

**Тайлбар 4:** Дэлхий нийтийг хамарсан Covid-19 цар тахлын улмаас үүссэн нийгэм эдийн засгийн хүндрэлийн нөлөө, хямрал бүрэн арилаагүй байхад 2022 оны 02 сард ОХУ болон Украин улсын хоорондын дайн нөхцөл байдлын улмаас ОХУ-аас Монгол улсад импортлогдох дизель түлшний хязгаарлалт тавигдсантай холбоотой дизель түлшний хомсдол үүссэн. Мөн гадна цаг агаар өмнөх жилүүдтэй харьцуулахад эрс хүйтэрч мөн манай улсын эдийн засгийн бүх салбар сэргэсэнтэй холбоотой дотоодын дулаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэгч станцуудын нүүрсний хэрэглээ огцом өсөн нэмэгдсэнтэй холбоотой Эрчим хүчний яам, Эрдэнэс Монгол ХХК, ДЦС-4, ДЦС-2, Амгалан дулааны станц болон бусад хэрэглэгчдээс нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасралтгүй найдвартай хангаж ажиллахыг үүрэг болгосон.

Энэ үед өөрийн хүчин чадлаас давсан ачаалалтай ажиллах болсон тухайн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийж худалдан авах ажиллагаанд гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулах арга хэмжээний хүрээнд сонгон шалгаруулалтыг оновчтой зохион байгуулж шатахуун импортлох тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдийн тэгш оролцоог хангаж нээлттэй өрсөлдөх боломж, худалдан авах ажиллагааны ил тод өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтүүдийг хамгийн боломжит нөхцөлөөр тусгасан болно.

Тендерийн шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэх, босгыг өндөрсгөх, шаардлагыг чангаруулах нь өрсөлдөөнийг хязгаарлаж хэдхэн монопол том компаниудад боломж олгосноор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална." гэсэн зарчим алдагдахад хүргэнэ гэж үзсэн.

Тухайн жилд зарлагдсан ШО/202201050, ШО/202209154 дугаартай сонгон шалгаруулалтуудад "Өү Жи Энержи Ойл" ХХК компани ганцаараа оролцож тендерийн үнэлгээний хорооны хурлын шийдвэрийн зөвлөмжийн дагуу тус тус сонгон шалгаруулан гэрээ байгуулж ажилласан болно.

**Асуулт 5:** "Шивээ Овоо" ХК-аас ШО/20250102029/01/01 дугаартай 33,922,462,353.00 төгрөгийн төсөвт өртөгтэй нээлттэй тендер шалгаруулалт зарласан бөгөөд анх удаа "Өү Жи Энержи Ойл" ХХК-аас гадна НИК ХХК, Содмонгол групп ХХК, Шунхлай ХХК зэрэг компаниуд өрсөлдсөн. Гэтэл "Шивээ овоо" ХК-ийн тендерийн үнэлгээний хороо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-д "Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадвар болон туршлагын шаардлагыг хангасан байна" гэж заасан үндэслэлээр НИК ХХК-ийн ирүүлсэн бага үнийн саналаас татгалзаж, "Өү Жи Энержи Ойл" ХХК-ийг шалгаруулсан нь хуульд нийцсэн эсэх;

**Тайлбар 5:** "Шивээ Овоо" ХК-иас 2025.02.21-ны өдөр зарлагдсан ШО/20250102029 Багц№01 дугаартай Дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг 2025.03.17-ны өдөр нээсэн. Сонгон шалгаруулалтад 10 компани оролцсон.

1. Сонгон шалгаруулалтад оролцогч "НИК" ХХК-ийн ирүүлсэн тендер нь Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-18.1-д заасан ижил төстэй гэрээний мэдээлэлд гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, захиалагч байгууллагын тодорхойлолтыг хавсарган ирүүлнэ гэсэн шаардлага /захиалагч байгууллагын тодорхойлолтыг хавсарган ирүүлээгүй/-ыг хангаагүй мөн ижил төстэй ажлын өртөг нь батлагдсан төсөвт өртгийн мөнгөн дүнгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй дизель түлш нийлүүлсэн байна гэсэн шаардлага /ижил төстэй гэрээний мэдээлэл шаардлага хангаагүй/-ыг хангаагүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17.4-д заасан чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй гэж үнэлэгдсэн байна.

2. Сонгон шалгаруулалтад оролцогч "Сод Монгол Групп" ХХК-ийн ирүүлсэн тендер нь Тендерийн баримт бичгийн III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын маягыг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17.4-д заасан чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй гэж үнэлэгдсэн байна.

3. Сонгон шалгаруулалтад оролцогч "Ди Би Ойл" ХХК-ийн ирүүлсэн тендер нь Тендерийн баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-25.1-д заасан тендерийн баталгааг ирүүлээгүй тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17.4-д заасан чадварын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй гэж үнэлэгдсэн байна.

4. Сонгон шалгаруулалтад оролцогч "Шунхлай трейдинг" ХХК шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн хэдий ч үнийн санал өндөр байсан.

Шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн оролцогч нарын үнийн саналыг танилцуулбал:

• "Өү Жи Энержи Ойл" ХХК-	12.824.867.989 төгрөг
• "Петро хаан" ХХК-	13.519.610.000 төгрөг
• "Либра энерги" ХХК-	13.698.282.000 төгрөг
• "Морьт говь ойл" ХХК-	13.779.961.900 төгрөг
• "Шунхлай трейдинг" ХХК-	14.017.547.450 төгрөг
• "Эн Пи Петролиум" ХХК-	14.730.304.100 төгрөгийн үнийн саналуудыг тус

тус ирүүлсэн байна.

Иймд шаардлагад нийцсэн гэж үнэлэгдсэн 6 оролцогч компаниудын тендерээс хамгийн бага үнийн санал ирүүлсэн "Өү Жи Энержи Ойл" ХХК шалгарсан байна.

**Асуулт 6:** "Өү Жи Энержи Ойл" ХХК нь "Шивээ Овоо" ХК-аас зарласан дизель түлш нийлүүлэх ШО/202107367/01/01, ШО/202209154/01/01, ШО/202201050/01/01, ШО/202201049/01/01, ШО/202301049/02/01, ШО/2024010231/02/01, ШО/20240102391/04/01, ШО/20250102029/01/01 дугаартай нийт 108,794,401,841.06 төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерүүдэд шалгарсан байх тул дээр дурдсан тендерүүдийн бичиг баримт боловсруулахаас эхлээд шалгаруулж, гэрээ байгуулах хүртэл үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэх талаар тендер тус бүрээр гаргасан дэлгэрэнгүй мэдээллийг мэдэгдэнэ үү.

**Тайлбар 6:** ШО/202107367/01/01, ШО/202209154/01/01, ШО/202201050/01/01, ШО/202201049/01/01, ШО/202301049/02/01, ШО/2024010231/02/01, ШО/20240102391/04/01 дугаартай нээлттэй сонгон шалгаруулалтад "Өү Жи Энержи Ойл" ХХК нь ганцаараа оролцож шалгарсан байна.

Дээр дурдсан сонгон шалгаруулалттай холбоотой 2021, 2022, 2023 онуудын баримт бичгүүдийг Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн 2024.07.16 өдрийн 06/11818 тоот албан бичгийн дагуу 2024.07.24-ны өдөр эх материалуудыг хүргүүлсэн тул одоо манай компанид байхгүй болохыг мэдэгдье.

Харин ШО/2024010231/02/01, ШО/20240102391/04/01, ШО/20250102029/01/01 дугаартай нээлттэй тендер сонгон шалгаруулалтуудын материалуудыг хуулбарлан цахим хэлбэрээр хавсарган хүргүүлж байна.

**Тайлбар: / Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2021 оны ШО/202107367 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын оролцогчийн мэдээлэл/**

Ш.Балсансүрэн | Түрэмж хэргийн | ТШЧ/202107367

Хувийн үндэс:	ШО/202107367/01/01	Түлшний төрөл:	Үр дүн гарсан
ТШЧ-ийн код:	ШО/202107367	ТШЧ-ийн нэр:	Дизель түлш
ТШЧ-ийн төрөл:	Үр дүн гарсан	Эхний журал:	Нэгдлийг төндөр шалгаруулалтын журал
ТШЧ-ийн төрөл:	Бирим	Засварлагч:	Шажуу-Овоо
Түрэмж хэргийн огноо:	2021-07-28	Төндөр хэргийн огноо:	2021-08-30 10:05:00
ТШЧ-ийн үнэ (т.т.д.т.):	Төлөв	Төндөр үнэ:	9,461,522,058

Төндрийн жагсаалт | Түрэмж хэргийн жагсаалт

← Төлөв

№	ТШЧ-ийн код	ТШЧ-ийн нэр	Төлөв	Оролцогчийн нэр	Төлөв	Шалтгаан
1	ШО/202107367/01/01	Дизель түлш	9,461,522,058	Шажуу-Овоо	Түрэл байгуулсан	

Хуудас: 1 | Нийт хуудас: 1 | 00 | Тийм | Биелэлт: 1

Төндөрт оролцогчийн жагсаалт

← Төлөв

№	Регистрийн дугаар	Оролцогчийн нэр	Эрх зүйн хэргийн үндэс	Санаал болгосон	Үнийн хэмжээг			Төлөв	Шалтгаан	Огноо	Эрх зүйн үндэс	
					Хувь	Дүн	Тооцсон				Мэдээлэл	Мөдөлдөг
1	ШО/202107367/01/01	Шажуу-Овоо	ШО/202107367/01/01	9,461,522,058	9,461,522,058	Шажуу-Овоо	Түрэл байгуулсан	2021-08-30	2021-07-28	2021-07-28	Шажуу-Овоо	Шажуу-Овоо

**Тайлбар:** Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2022 оны ШО/202201050 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын оролцогчийн мэдээлэл /

Урьдчилсан дүгнэлт:	ШО/202201050/01/01	Төрийн нэр:	Үр дүн гарсан
ТӨ-ийн код:	ШО/202201050	Төлөөлөл:	Дизель түлш 2
ТӨ-ийн төлөв:	Үр дүн гарсан	Мэдээлэл:	Нэгдлийг төлөв шалгаруулалтын журим
ТӨ-ийн төрөл:	Барил	Замнал:	Шинэ Огно
Эрхийн өмчлөлтийн огноо:	2022-01-31	Төлөв өөрчлөлтийн огноо:	2022-05-04 10:20:00
Төлөөлөлтийн өсөлт:	Байх	Төлөв өөрчлөлт:	9,880,241,520

Төрийн жагсаалт  Удиртгалийн хэргийг

**Төлөв**

№	ТӨ-ийн код	ТӨ-ийн нэр	Төлөв өөрчлөлт	Оролцогчийн төр	Төлөө	Шалтгаан
1	ШО/202201050	Дизель түлш 2	9,880,241,520	1	<b>Лавчирсан</b>	

Хуудас: 1 | Тийш үргэлжлэх  | Тийш Сийлэх

Төрийн оролцогчийн жагсаалт

**Төлөв**

№	Регистрийн дугаар	Оролцогчийн нэр	Эрхийн хязгаарлуулсан өсөлт	Санал болгосон	Урьдчилсан мэдээлэл			Төлөө	Шалтгаан	Огноо	
					Хуви	Дүн	Төсөвт			Огноо	Мэдээлэл
1	УТӨ0001	Өвчлөлийн үйлчилгээний төв	<b>3.17</b>	9,376,721,400		9,376,721,400	<b>Шалгарсан</b>	ШААРГАВАХ АЖИЛЛАГАА	2022-05-04	УТӨ0001-01-01-000001-01	

**Тайлбар:** Терийн худалдан авах ажиллагааны цахим системд 2022 оны ШО/202209154 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын оролцогчийн мэдээлэл

Урьдчилсан дугаар	ШО/202209154/01/01	Урьдчилсан төлөв	Үр дүн гарсан
ТӨ-ийн код	ШО/202209154	ТӨ-ийн код	Дизель түлш /хөнгөл сэлүүршил/
Тогтмол төсөв	Үр дүн гарсан	Хуучин журал	Нэгилтэй тендер шалгаруулалтын журал
Төлөөн төрөл	Бараг	Танхиагчид	Шингэ-Олон
Хуралын өндөрний огноо	2022-09-30	Тендерийн өмнө огноо	2022-10-31 10:05:00
Үр дүн шалгаруулсан өсөгч	<b>Шингэ</b>	Төсвийн өртөг	9,797,894,150

**Тендерийн жагсаалт** Үндэслэлний хөрөө

**Төлөө**

№	ТӨ-ийн код	ТӨ-ийн нэр	Төсвийн өртөг	Оролцогчийн төр	Төлөө	Шалтгаан
1	ШО/202209154	Дизель түлш /хөнгөл сэлүүршил/	9,797,894,150	t	Дотоо байгууллагад	

Хуудал: 1 | Тэнгэр хуудал: 1 | 10 | 1 | Хуучин төсвийн код: 1

**Тендерт оролцогчийн жагсаалт**

**Төлөө**

№	Регистрийн дугаар	Оролцогчийн нэр	Зэвсэг хялгаруулсан өсөгч	Самал болгосон	Үнийн хэмжээг			Төлөө	Шалтгаан	Түрэн байгуулах арга оролц	
					Хувь	Дүн	Тодруулсан			Огноо	Мэдээлэл
1	447100	Шингэ-Олон	<b>Шингэ</b>	9,797,894,150		3,024,493,120	<b>Шингэ-Олон</b>	МОНГО	2022-11-30	2022-11-30	2022-11-30

**Тайлбар:** / Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2023 оны ШО/202301049 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын оролцогчийн мэдээлэл/

Төлний дугаар	ШО/202301049/02/01	Төлний төрөл	Үр дүн гарсан
ТШ-ны код	ШО/202301049	ТШ-ны нэр	Дизель түлш
Төлний төлөв	Үр дүн гарсан	МАН-н зэрэг	Нэгдлийг төсвэр шалгаруулалтын журим
Төлний төрөл	Бараа	Төлөвөлөгч	Шивээ-Овоо
Хэрэглээний өдөр	2023-03-07	Төндөр өдөр өгөгж	2023-04-06 10:15:00
Тр-дүн нийлэгчин үнэ	53,953,742,517	Бичиргэний үнэ	53,953,742,517

Төндөрний жагсаалт Төлөвөлөгчийн жагсаалт

← **Гэрээ гэрээлсэн**

№	ТШ-ны код	ТШ-ны нэр	Төсөлт өртөг	Оролцогчийн тоо	Төлөв	Шалтгаан
1.	ШО/202301049	Дизель түлш	53,953,742,517	1	Гэрээ байгуулсан	

Төндөр оролцогчийн жагсаалт

← **Төлөв**

№	Регистрийн дугаар	Оролцогчийн нэр	Эрх зөвшөөрсөн хэмжээ	Санал болгосон	Үнийн өмнөлт			Төлөв	Шалтгаан	Гэрээ байгуулах эрхэмлэг	
					Хувь	Дүн	Тооцог			Огноо	Мэдэгдэл
1.	202301049	Ш-ны төлөв	53,953,742,517	53,953,742,517	53,953,742,517	53,953,742,517	Шалгарсан	Эрхийн болон санал зүйлсийн өмнөхөд эрхэмлэг болон хамт бүртгэлт оролцогч илэр үзэж үзүүлэн 29.14 хувийг илэрлээ.	2023-04-06 10:15:00	2023-04-06 10:15:00	

**Тайлбар:** Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2024 оны ШО/20240102031 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын оролцогчийн мэдээлэл/

Регистрийн дугаар	ШО/20240102031/02/01	Түлшний төрөл	Үр дүн гарсан
ТШ үнэ код	ШО/20240102031	ТШ үнэ нэр	Дизель түлш
ТШ үнэ өмнө	Үр дүн гарсан	Эзлэх журмыг	Нэгдлийн тендер шалгаруулалтын эрх
ТШ үнэ нэрлэл	Бариан	Төлөөлөгч	Шинэ-Огноо
Түрээс нийлүүлэх огноо	2024-02-14	Тендер өгөх огноо	2024-01-06 09:05:00
Түрээс нийлүүлэх эхэл	Төлөө	Тендер өртөг	26,752,993,773

Тендерийн жагсаалт    Тендер төлөлийн жагсаалт

← Огноо

НР	ТШ үнэ код	ТШ үнэ нэр	Төлөөлөгч	Оролцогчийн эрх	Төлөв	Шалтгаан
1	ШО/20240102031	Дизель түлш	26,752,993,773	1	Гүйцэтгэгч байхгүй	

Төлөв:    ТШ үнэ код: ШО/20240102031/02/01    ТШ үнэ нэр: Дизель түлш

Тендер оролцогчийн жагсаалт

← Огноо

НР	Регистрийн дугаар	Оролцогчийн нэр	Түрээс хангааруулсан эхэл	Самал болгосон	Үнийн хэмжээг			Төлөв	Шалтгаан	Гүйцэтгэгч байхгүй эрх огтло	
					Хувь	Дүн	Толдсон			Огноо	Мэдээлэл
1	ШО/20240102031	Шинэ-Огноо	Төлөө	26,752,993,773	75,507,401,740	75,507,401,740	Бэлэн	шалгарсан	2024-01-14	Шинэ-Огноо 062 138 337	

**Тайлбар:** Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2024 оны ШО/20240102391 дугаартай дизель түлш нийлүүлэх нийлүүлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын оролцогчийн мэдээлэл

Төрийн дугаар	ШО/20240102391	Төрийн төсөв	Тр дүн өрсөлд
ТӨН код	ШО/20240102391	ТӨН нэр	Дизель түлш /дизелийн/
ТӨН төрөл	Тр дүн өрсөлд	Мэдээ мэдээл	Нэгдсэн төлөв шалгаруулалтын эргэ
ТӨН төрөл	Борил	Санхиад	Өмчлөх-Өвчлөх
Хэрэглэх хугацаа (сая.төг)	2024-11-21	Төндөрт өртөг (төг)	2024-11-11 09:05:00
Түрэлдэж байгаа эхэл	Тайл	Төндөрт өртөг	4,080,474,090

**Төндөрт өртөгний жагсаалт** Түрэлдэж байгаа эхэл

**Төндөрт өртөгний жагсаалт**

№	ТӨН код	ТӨН нэр	Төндөрт өртөг	Оролцогчдын тоо	Төлөв	Шалтгаан
1	ШО/20240102391	Дизель түлш /дизелийн/	4,080,474,090	6	Түрэлдэж байгаа эхэл	

**Төндөрт оролцогчийн жагсаалт**

**Төндөрт оролцогчийн жагсаалт**

№	Регистрийн дугаар	Оролцогчийн нэр	Түрэлдэж байгаа эхэл	Сонгох болсон	Үндийн мэдээлэл			Төлөв	Шалтгаан	Түрэлдэж байгаа эхэл	
					Хүн	Дүн	Туслах			Огноо	Мэдээлэл
1	171134	И.Х.Холбоо ОХ	Төндөрт өртөг	1,174,644,917	1,174,644,917	Төндөрт өртөг	Төндөрт өртөг	2024-11-11	И.Х.Холбоо ОХ-ийн үйлдвэр		